



USAID
FROM THE AMERICAN PEOPLE



Economic Policy Reform and
Competitiveness Project

ЭЗБШӨЧ төслийн сар тутмын цуврал

2007 оны 11 дүгээр сар

Монголын Ипотекийн Корпорац (МИК) 1.1 сая ам.долларын мортгэйжийн зээл худалдан авлаа

11-р сарын 5-ны өдөр болсон ёслолын арга хэмжээ, хэвлэлийн бага хурлын үеэр МИК, ХасБанк нь Монгол улсын мортгэйжийн хоёрдогч зах зээлийн анхны гэрээнд гарын үсэг зурлаа. Гэрээний дагуу МИК зохих шалгуур хангасан нийт 1,033,898.04 ам.долларын мортгэйжийн зээлийн багц худалдан авахаар тохиролцсон.



Энэ нь МИК-иар дамжуулан үнэт цаасжуулах нийт 3,099,900 ам.долларын гурван тэнцүү багцын эхнийх нь хэсэг юм. Мортгэйжийн зээлийн багцын эхний энэ хэсэгт Улаанбаатар хот орчмын 139 орон сууцанд олгосон мортгэйжийн зээл хамрагдаж байна. Эдгээр мортгэйжийн зээл нь жилийн 14 хувийн дундаж хүүтэй, ам.доллараар олгогдсон, ам.долларын 6 сарын жишиг хүүтэй, хагас жил тутам хүүгээ шинэчлэх боломжтой юм.

ХасБанк мортгэйжийн багцаар үргэлжлүүлэн үйлчлэх болно. Талууд үйлчилгээний гэрээнд гарын үсэг зурж, үүндээ үнэт цаасжуулаагүй болон үнэт цаасжсан мортгэйжийн зээлийн зохицуулалт, үүний дотор эргэн төлөлт хийгдэхгүй болсон, мөн зээлийн төлбөрийг барагдуулсны дараахь үйлчилгээний нөхцөл болзлыг тодорхойлно. МИК нь мортгэйжийн зээлийн багц худалдаж авсныхаа дараа 45 хоногт багтаан МИК-ийн Мортгэйжийн зээл сонгон шалгаруулах шалгуур үзүүлэлтүүдийг хангаж, тэдгээртэй нийцэж буй эсэхийг шалгаж, баталгаажуулах зорилгоор файл тус бүрийг нэг бүрчлэн судлах юм.

МИК худалдан авсан мортгэйжийн зээлээ үнэт цаасжуулахын тулд ам.доллараар нэрлэсэн орон сууцны мортгэйжээр баталгаажсан үнэт цаас (МБҮЦ) гаргаж, хөрөнгө оруулагчдад шууд эсхүл зуучлах агентаар дамжуулан борлуулж байршуулахаар төлөвлөж байна. МИК-

иас худалдан авч үнэт цаасжуулсан мортгэйжийн зээл нь эргээд ХасБанкны хөрөнгийг нэмэгдүүлж илүү олон тооны мортгэйжийн зээл олгох боломж бүрдүүлэх төдийгүй хөрөнгийн зах зээлд санхүүгийн шинэлэг бүтээгдэхүүн гаргах, санхүүгийн шинэ эх үүсвэр бий болгох, мортгэйжийн зээлийн эрсдэлийг төрөлжүүлж, тайлан балансын удирдлагыг сайжруулах юм. МИК-ийн МБҮЦ нь дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдад эрчимтэй хөгжиж буй мортгэйжийн зах зээлд оролцох, өндөр чанартай, түргэн арилжигдах үнэт цааснаас их хэмжээний орлого олох боломж олгож байна.

УИХ-ын Ажлын хэсэг орон сууцны санхүүжилтийн урьдчилгаа төлбөрт дэмжлэг үзүүлэх хөтөлбөрийг хэлэлцэв

Төсөл УИХ-ын Орон сууцны болон орон сууцны санхүүжилтийн хамтарсан Ажлын хэсэг (УИХ-ын АХ)-тэй 11-р сарын 20-ны өдөр уулзаж, арилжааны банкуудаар дамжуулан олгох мортгэйжийн зээлд хамрагдах шалгуурыг хангасан бага, дунд орлоготой өрхүүдийн мортгэйжийн зээлийн урьдчилгаа төлбөрт дэмжлэг үзүүлэх хөтөлбөрийн төслийг танилцуулж презентаци тавив.



Энэ презентаци нь 2005 оноос эхэлсэн Монгол Улсын Их хурал, Засгийн газарт бага, дунд орлоготой өрхүүдийн орон сууцны зээлийн хүртээмжийг сайжруулах эрх тэгш, удирдан зохицуулж болохуйц хөтөлбөрийг боловсруулахад туслалцаа үзүүлэх Төслийн ажлын нэг хэсэг байсан юм.

Презентацийг орон сууцны санхүүжилтийн олон улсын эксперт Габриэль Наги тавьсан бөгөөд үүнд УИХ-ын хамтарсан Ажлын хэсгийн ахлагч УИХ-ын гишүүн Т. Очирхүү, гишүүн Д. Ганхуяг, Ц. Дамиран, З. Энхболд нар оролцов. Уулзалтад оролцсон УИХ-ын АХ-ийн гишүүд бага орлоготой өрхүүдэд зориулсан мортгэйжийн зээлийн урьдчилгаа төлбөрт дэмжлэг үзүүлэх хөтөлбөрүүд болон тэдгээрийн Мексик, Колумби, Чили улсад амжилттай хэрэгжсэн туршлагыг ихэд сонирхож байлаа.

Энэхүү цувралд нийтлэгдсэн санаа бодол нь АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг болон АНУ-ын Засгийн газрын байр суурийг заавал илэрхийлсэн байх албагүй болно.

Сайтар боловсруулагдаж, хэрэгжсэн мортгэйжийн зээлийн урьдчилгаа төлбөрт дэмжлэг үзүүлэх хөтөлбөрийн үр дүнд:

- Шалгуур хангасан бага, дунд орлоготой өрхүүдийн орон сууцны нөхцөл сайжирна
- Бага орлоготой өрхүүд арилжааны зээлийн санхүүжилтэд хамрагдах боломж нэмэгдэнэ
- Зорилтот хүн амыг зохих ёсоор тодорхойлж үйлчилснээр орон сууцны хэрэгцээ шаардлагагүй хүмүүсийг татааст хамруулахаас зайлсхийж чадна
- Санхүүгийн дэмжлэгийг төсөвт суулгаснаар хүмүүс энэ талаар сайн мэддэг болж, төсвийн ил тод байдал сайжирна
- Өргөдөл гаргагчид, хөтөлбөрт хамрагдагсад, нийт хүн ам нь өргөдөл гаргах, сонгох, татаас олгох дүрэм



журмыг сайтар мэддэг болсноор хэн нэгэн давуу эрх эдлэх явдал гарахгүй болно

- Бага, дунд орлоготой өрхүүдэд мөнгөн хадгаламжаа илүү үр ашигтай зарцуулахад тусална
- Мортгэйжийн зээлийн санхүүжилтийн хөрөнгийг зах зээлийн ханшаар хувийн хэвшлээс татах боломж бүрдэж, бага, дунд орлоготой өрхүүдэд зориулсан орон сууцны санхүүжилтийн хөрөнгийн эх үүсвэр нэмэгдэнэ
- Төр, хувийн хэвшлийн бие биеэ нөхсөн, хамтын үүрэг хариуцлагатай төр-хувийн хэвшлийн түншлэл бодитойгоор хөгжинө, төр нь орон сууцны санхүүжилтийн бодлогыг хэрэгжүүлэн зохицуулж, харин хувийн хэвшил нь санхүүжилтийн хөрөнгөөр хангаж, зээллэгийн эрсдэлийг удирдана.

Хөтөлбөрийг Монгол улсад хэрэглэх, хэрэгжүүлэх талаар хэлэлцсэн энэхүү ажил хэрэгч ярилцлагын дараа УИХ-ын АХ-ээс Төсөлд хандан дараахь хүсэлт тавьсан юм. Үүнд:

- Зохих шалгуурыг хангасан бага орлоготой өрхүүдэд арилжааны банкаар дамжуулан олгох мортгэйжийн зээлийн урьдчилгаа төлбөрт дэмжлэг үзүүлэх Монгол улсын үндэсний хөтөлбөрийн төслийг боловсруулж хэлэлцүүлэгт бэлтгэх
- Монгол улсад хэрэгжих энэхүү хөтөлбөрийн зохион байгуулалт, үйл ажиллагааны загварыг гаргаж тусгайлсан зөвлөмж боловсруулах, үүндээ төсөвт зардлын тооцоо, санхүүжилтийн бусад механизмыг оруулах
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх журам боловсруулах, үүнд өргөдөл гаргах, үнэлгээ хийх, татаас олгох журам, стандарт баримт бичгийн бүрдэлтийг оруулах.

ЭЗБШӨЧ төсөл УИХ-ын АХ-ийн ажлыг дэмжиж, тавьсан хүсэлтийн дагуу зохих баримт бичгийг урьдчилсан байдлаар боловсруулах, хөтөлбөрийн цаашдын зөвлөлдөх уулзалт, олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах боломж бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэхээр тохиролцов.

Гаалийн хуулийн нэмэлт өөрчлөлтийн талаар Бизнес эрхлэгчид-Засгийн газрын дугуй ширээний ярилцлага боллоо

Төсөл нь 11-р сарын 21-ний өдөр Монгол Улсын Гаалийн ерөнхий газрын хүсэлтээр Гаалийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн төслийн талаар дугуй ширээний ярилцлага зохион байгуулсан бөгөөд уг ярилцлагыг Төсөл, ТаванБогд групп ивээн тэтгэлээ. Энэхүү арга хэмжээнд хувийн хэвшлийн 57 оролцогчид, Гаалийн байгууллагын 20 гаруй ажилтнууд оролцов.

Дугуй ширээний ярилцлагын зорилго нь Гаалийн болон Гаалийн тарифын тухай хуульд оруулах нэмэлт



өөрчлөлтийн төслийг УИХ-аар хэлэлцэхээс өмнө худалдаа, гаалийн үйл ажиллагаанд оролцдог хувийн хэвшлийнхнээр хянуулах, саналаа өгөх боломжийг нь бүрдүүлэхэд оршиж байв.

Санал болгож буй хуулийн төслийг оролцогчдод урьдчилан хүргүүлсэн байсан бөгөөд нэмэлт өөрчлөлтийн талаар саналаа тусгайлан өгөх боломжоор хангахын тулд тэднийг ярилцлагын гурван бүлэгт хуваасан юм. Ярилцлагын бүлэг тус бүр тусгайлсан сэдвүүдэд, тухайлбал гаалийн тариф, гаалийн баримт бичгийн бүрдэлт, хяналт шалгалт болон гаалийн байгууллага, худалдаа эрхэлдэг байгууллагын хоорондын харилцаа, үүний дотор тэдгээрийн эрх, үүрэг, хариуцлага зэрэгт төвлөрч байв. Тусдаа явагдсан ярилцлагын эцэст бүлэг тус бүрийг төлөөлсөн нэг хүн гаалийн хуулийн нэмэлт өөрчлөлтийн төслийн талаархи өөрсдийн саналаа танилцуулсан юм. Оролцогчдоос гарсан санал, санал болгосон нэмэлт өөрчлөлтийн дийлэнх нь маш дэлгэрэнгүй техникийн чанартай байсан боловч ерөнхийдөө дараахь агуулгатай байв. Үүнд:

- Гаалийн болон худалдааны үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн болон техникийн хэллэг, нэр томъёог тодорхой болгож, тэдгээрийг олон улсын хэллэг, нэр томъёотой нийцүүлэх
- Хуулийн төслийн заалтуудыг Тээврийн тухай, Тусгай зөвшөөрлийн тухай болон холбогдох бусад хууль, журамтай нийцүүлэх
- Ойлголт, нэр томъёоны давхардлыг арилгах
- Хууль батлагдсаны дараа ГЕГ-аас гарах холбогдох дүрэм журмын боловсруулалт, дугуй ширээний ярилцлагад хувийн хэвшлийнхнийг оролцуулах.



Төсөл нь бүх оролцогчдын зүгээс санал бодлоо хуваалцаж, хянаж, зөвшилцсөн саналыг нэгтгэн баримтжуулахад тулалцаа үзүүлэв. Гаалийн тухай хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн төсөлд оруулах саналыг нэгтгэсэн энэхүү баримт бичгийг ярилцлагад оролцсон бизнес эрхлэгчдээр эцсийн байдлаар хянуулсны дараа ГЕГ-т хэлэлцүүлэхээр хүргүүлэх юм.

Дугуй ширээний ярилцлагад оролцсон бүх бизнес эрхлэгчид Гаалийн ерөнхий газраас бизнесийн асуудалд нээлттэй хандаж, асуудлыг хүлээн авч шийдэж байгааг нэгэн дуугаар сайшааж байв. Тэд ГЕГ-ын үйл ажиллагаагаа болон ил тод байдлаа сайжруулах хүчин чармайлтыг өөрсдийн зүгээс дэмжихээ илэрхийлж байлаа.

Түүнчлэн ярилцлагад оролцогчид бизнес эрхлэгчид-засгийн газрын дугуй ширээний энэхүү ярилцлагыг энэ төрлийн цуврал арга хэмжээний анхных нь гэж үзэх ёстойг онцлон тэмдэглэлээ. ГЕГ болон бизнес эрхлэгчид аль аль нь тулгамдаж буй асуудлаа харилцан сонсох энэ арга хэмжээг цаашид тогтмолжуулах, бизнесийн таатай орчинг хөхиүлэн дэмжих эрх зүйн хүрээ, гаалийн дүрэм журмыг сайжруулах чиглэлд хамтран ажиллахад бэлэн байгаагаа илэрхийлсэн юм.

Монголын төлөөлөгчид Лондон хотноо болсон 2007 оны Дэлхийн Аялал жуулчлалын зах зээлийн үзэсгэлэнд оролцов

Зам, тээвэр, аялал жуулчлалын яамнаас (ЗТАЖЯ) тавьсан хүсэлтийн дагуу Монголын Үндэсний аялал жуулчлалын байгууллага (ҮАЖБ) энэ оны 11 дүгээр сарын 12-15 хооронд Лондон хотноо зохион байгуулагдсан 2007 оны Дэлхийн Аялал жуулчлалын зах зээлийн үзэсгэлэнд монголын тур операторуудыг оролцуулах арга хэмжээг зохион байгуулав. Энэхүү үзэсгэлэнд 5 тур оператор, ЗТАЖЯ, МИАТ, Монголын Төмөр зам, Изнис Эарвейс компани, Кемпински Хаан Палас зочид буудал, Sixth Rental Car машины түрээсийн компани, Монголын Аялал жуулчлалын холбоо болон ҮАЖБ-ын төлөөлөгчид оролцлоо.

Үзэсгэлэнгийн талбайн дизайн, сурталчилгааны бэлтгэл ажил, хэвлэлийнхэнд тараах сурталчилгааны материал, олон улсын хэвлэл мэдээллийн төлөөлөгчдөд зориулан Их

үзэж сонирхжээ. ВВС-ийн ажилтан ноён Амита Наяк, Бредфорд группын ахлах ажилтан хатагтай Карен Хофман нар 2008 оны зун Монголд үнэгүй аялах эрхийн бичгийг сугалав.

Монголын аялал жуулчлалын зах зээлийн тав дахь эх үүсвэрийн хувьд Их Британы аялал жуулчлалын зах зээл нь 5500 гаруй жуулчдыг гаргадаг байна. Энэ тоог нэмэгдүүлэхийн тулд Британы аялал жуулчлалын зах зээл дээр Монголын брэнд, имижийг бий болгох талаар ҮАЖБ-ын төлөөлөгчид болон бусад оролцогчид нилээн хүчин чармайлт гаргаж ажиллав. Үүний үр дүнд дараах тохиролцоонд хүрчээ:

- Хойд Америкийн зах зээл дээр Монголыг сурталчлах кампанит ажлыг зохион байгуулах талаар Бредфорд групптай гэрээ байгуулахаар тохиролцов; энэ оны 1 дүгээр сард болох 2008 оны Нью-Йорк Таймс Аялал жуулчлалын арга хэмжээний үеэр ҮАЖБ-аас Бредфордтой хамтран хэвлэлийнхэнд зориулсан өглөөний цайг ивээн тэтгэх болов; хатагтай Хофман болон Хойд америкийн зарим хэвлэл мэдээллийн төлөөлөгчид энэ оны эцсээр Монголд зочлоно;
- ЗТАЖЯ Харилцан ойлголцолын санамж бичигт гарын үсэг зурсаны дараа ҮАЖБ 2009 онд болох Land Rover G4 Challenge авто раллиг зохион байгуулах гол түнш байгууллагуудын нэгээр ажиллана.
- ҮАЖБ Одиссей Гайдс Бук (Odyssey Guides Book)-аас хэвлэн нийтлэх "Монголын тухай лавлах"-ын 550 хуудсыг хамтран гаргана.
- Дөрвөн тур оператор өөрсдийн 30 түнштэй гэрээгээ шинэчлэн байгуулав.
- Гурван тур оператор өөрсдийн түншүүдтэй 19 шинэ гэрээнд гарын үсэг зурав.
- Таван тур оператор 16 шинэ түнштэй холбоо тогтоов.
- Хоёр тур оператор аялал жуулчлалын зах зээлийнхээ цар хүрээг Их Британи, Израиль, Белги, Швейцари, Канад, АНУ зэрэг орнуудтай өргөтгөв.

Үзэсгэлэнд оролцогчид болон тур операторууд энэхүү арга хэмжээний үеэр гаргасан амжилт, байгуулсан гэрээний талаар сэтгэл хангалуун байлаа. Үүнээс гадна уг үзэсгэлэн нь Монгол Улсыг аялал жуулчлалын зорих газар болгон бэхжүүлэхэд тус дөхөм болно гэж тэд үзэж байгаа бөгөөд энэхүү зах зээлийн жуулчдын тоо цаашид улам нэмэгдэнэ гэдэгт мөн итгэлтэй байна.

Эрчим хүчний ажлын хэсгийн зургаа дахь уулзалт болов

Эрчим хүчний ажлын хэсгийн уулзалт энэ оны 11 дүгээр сарын 15-нд болж, уулзалтанд Түлш, эрчим хүчний яамны ажилтан Сүхбаатар, АНУ/ОУХА-ийн дарга Б.Прим, ЭХЗГ-ын дарга Ганжуур, ТӨХ-ны ажилтан Баалийхүү, АХБ-ны төлөөлөгч А.Руфенберг, Дэлхийн Банкнаас Түмэнцогт, ЕСБХБ-аас Н.Туул, Сангийн яамнаас Гаадулам, ЭЗБШӨЧ төслөөс Амгалан, Ф.Бертоли, Р.Браун нар оролцов. Энэ нь 2007 оны 4 дүгээо сард болсон Монгол Улсын Засгийн газар, Гадаад түншүүдийн техникийн уулзалтаас хойш ТЭХЯ, АНУ/ОУХА-ын хамтран зохион байгуулж байхаар тохирсон Эрчим хүчний ажлын хэсгийн зургаа дахь уулзалт юм.

Уулзалтын үеэр дараах гол асуудлыг хэлэлцсэн болно. Үүнд:

1. **Олон нийтийн мэдээлэл/ Олон нийтийн боловсрол (ОНМ/ОНБ).** Олон нийтийн боловсролыг дээшлүүлэх кампанит ажлын хүрээнд хийж буй ажлын талаар төслийн зүгээс мэдээлэл хийж "Асуудал, баримт, санал



бодол: Телевизийн цуврал нэвтрүүлэг"-ийн тухай тойм мэдээллийг тараав. Мөн олон нийтэд техникийн шинж чанартай мэдээллийг илүү хүртээмжтэй болгох зорилго бүхий телевизийн санал болгож буй цуврал нэвтрүүлгийн онцлогийн талаар дэлгэрэнгүй тайлбар хийлээ. Энэхүү кампанит ажил нь ТЭХЯ болон олон нийтийн хувьд чухал ач холбогдолтойг ноён Сүхбаатар тэмдэглээд салбарын компаниудын үйл ажиллагааг зах зээлийн харилцаанд шилжүүлэх шаардлагатайг онцлон заав.

2. Нүүрсний үнийн өсөлт. Шарын голын уурхайн нүүрсний үнийг нэмэгдүүлэх боломж, аргачлалын талаар ноён Сүхбаатар товч танилцуулж, ТЭХЯ-ны сайдын зөвлөлийн дараагийн хуралдаанаар нэг тонн нүүрсний үнийг 3000 төгрөгөөр нэмэгдүүлэх тухай Шарын голын уурхайгаас тавьсан саналыг хэлэлцэхээр болов. Ингэхдээ аль ч уурхайн нүүрсний үнэ санал болгож буй үнээс дээш гарахгүй байх болно.

3. Онцгой байдлын бэлтгэл ажил. АНУ-ын элчин сайдын яам, Стратегийн судалгааны Ази, Номхон далайн бүсийн төвийн (ССАНДТ) ивээл дор онцгой байдлын бэлтгэл ажлын төлөвлөгөөг боловсруулах ажлын явцын талаар АНУ/ОУХА-аас танилцуулав. Улаанбаатар хотод дулааны шугам сүлжээний алдагдлаас гарч буй онцгой байдлын бэлтгэл ажилд үнэлгээ өгч, бүх оролцогч талуудтай уулзах зорилго бүхий баг 12 дугаар сарын 4-ний үеэр Улаанбаатар хотод зочлоно.

4. Гүйцэтгэлийн гэрээ. ЭХЗГ, Багануур болон Зүүн өмнөд бүсийн Цахилгаан түгээх компанийн хооронд байгуулсан Гүйцэтгэлийн гэрээний явцын талаар ЭХЗГ-аас танилцуулав. Зуны улиралд цахилгааны мөнгө хураах үйл ажиллагаа сулардаг тул гуравдугаар улирлын байдлаар гүйцэтгэлийн гэрээнд заасан зорилтод хүрсэн эсхүл зорилтыг давуулан биелүүлсэн тусгай зөвшөөрөл эзэмшигч бүхий компаниудад олгохоор төсөвлөсөн жилийн урамшууллын хэмжээ 60 сая төгрөгөөс 20 сая төгрөг хүртэл буурчээ. Тусгай зөвшөөрөл эзэмшигч бусад компаниудтай гүйцэтгэлийн ижил гэрээ байгуулахын тулд Гүйцэтгэлийн анхны гэрээг амжилттай хэрэгжүүлэхийн чухлыг ноён Ганжуур онцлон тэмдэглэлээ. Тэрээр цааш нь Гүйцэтгэлийн гэрээг сайн дурын үндсэн дээр ЭХЗГ, тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн хооронд харилцан тохиролцож байгуулдаг талаар яриу.

5. Компанийн засаглал. Тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын засаглалыг сайжруулах талаар ТӨХ ажиллаж буй тухай ноён Баалийхүү танилцуулж энэ талаар ЭЗБШӨЧ төслөөс гаргасан зөвлөмжийн талаарх саналыг мөд танилцуулна гэж мэдэгдэв. Тэрээр энэ асуудлаар хувь нийлүүлэгчдийн уулзалтыг зохион байгуулахын чухлыг тэмдэглээд (одоогоор энэ уулзалт болоогүй байгаа) компанийн засаглалыг бий болгоход ЭХАХ-аас туслалцаа үзүүлэхийг хүсэв. Тусгай зөвшөөрөл эзэмшигч бүх компаниудын 2007 оны аудитаар орсон санхүүгийн эцсийн тайланг Олон улсын

Санхүүгийн тайлангийн стандартад (ОУСТС) нийцэж буйг хангахын тулд 2008 онд ЭЗБШӨЧ төслийн зүгээс компанийн засаглалыг хөгжүүлэхэд дэмжлэг туслалцаа үзүүлэх болно гэдгээ төслийн удирдагч ноён Бертоли мэдэгдэв.

6. Эрчим хүчний салбарт олгох улсын төсвийн татаас. Эрчим хүчний салбарт улсын төсвөөс татаас олгож байх тухай хүсэлтийг ЭХАХ-ийн нэрийн өмнөөс Сангийн яамны Зээл тусламжийн бодлого, зохицуулалтын газрын дарга ноён Эрдэмбилэгт бичгээр явуулахыг хатагтай Гаадулам санал болгов. Мөн ЭХАХ-ийн дараагийн уулзалтын өмнө ажлын хэсгийн гишүүдийг ноён Эрдэмбилэгтэй уулзахыг зөвлөв.

7. Эрчим хүчний тухай хууль. 2001 онд баталсан одоогийн мөрдөж буй Эрчим хүчний тухай хууль болон энэхүү хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн талаар гаргасан саналыг ТЭХЯ-аас тараав. Санал болгож буй нэмэлт өөрчлөлтүүд нь хэдийгээр өмнөхөөсөө нилээн сайжирсан боловч ноён Баалийхүү болон ЭЗБШӨЧ төслөөс санал болгосон барилгын зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагын тухай асуудал, эрчим хүчний үнийг индексжуулах, нүүрсний үнэ тогтоох аргачлалын ТЭХЯ-ны бүрэн эрхийг ЭХЗГ шилжүүлэх зэрэг асуудал тусгагдаагүй байгааг тэмдэглэв. Одоогийн тариф тогтоох явц хэтэрхий улс төржсөн байдлыг тэмдэглээд хуулийг илүү тодорхой болгох нь зүйтэй гэж ноён Сүхбаатар хэлэв. Тэрээр хуулинд оруулах нэмэлт өөрчлөлтүүдийн тухай хуулийн төсөл болон нэмэлт заалтууд 2008 оны 1 дүгээр сард гарах тухай мэдэгдэв. Тарифтай холбоотой асуудлыг "суурь хууль" болох Эрчим хүчний тухай хуулинд бус харин яам, ЭХЗГ-аас баримталж буй дүрэм журманд оруулах нь зүйтэй гэсэн саналыг ноён Прим дэвшүүлэв. ЭЗБШӨЧ төсөл ба ЭХЗГ хамтран хуулинд оруулах нэмэлт өөрчлөлтүүдийн талаар нарийвчлан ярилцаж өөрсдийн гаргасан зөвлөмжийг ТЭХЯ-нд хэлэлцүүлэхээр хүргүүлээд байна. Одоогоор янз бүрийн яам, агентлагуудад төвлөрөөд байгаа эрчим хүчний нөөцийн менежментийн талаар хийх институцийн зохицуулалтын ач холбогдлыг ноён Сүхбаатар цохон заав. ЭХАХ-ийн уулзалтанд Үйлдвэр, худалдааны яамнаас төлөөлөгч урьж оролцуулаа гэсэн ноён Примын саналыг ажлын хэсгийнхэн дэмжлээ.

Дараа оны 1 дүгээр сард болох ЭХАХ-ийн уулзалтаар тодорхой авах арга хэмжээний талаар ярилцахаар болов.

Энэхүү цуврал нь ЭЗБШӨЧ төслийн үйл ажиллагааны тухайн сар тутмын цахим хэвлэл юм. Та өөрийн санал бодол, манай цувралыг захиалах буюу захиалгаа цуцлах хүсэлтийг ЭЗБШӨЧ төслийн цуврал хариуцсан эрхлэгчид дараах хаягаар ирүүлнэ үү.
И-мэйл fbertoli@eprc-chemonics.biz, факс: (976-11) 32 78 25.

